Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын ...-ны өдрийн ..... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

# ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

***Товч удирдамж:*** *Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.*

## НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

| | |
|---|---|
| **1.1** | **Эцэг/эхийн нэр:** Мондоохой<br>**Ургийн овог:** Мөөшөө<br>**Нэр:** Нямсүрэн<br>**Хүйс:** Эрэгтэй<br>**Төрсөн он:** 1976<br>**Төрсөн газар:** Увс аймгийн Тэс сум<br>**Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг[redacted] |
| **1.2** | **Иргэний харьяалал**<br>Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. |
| | Тийм |
| **1.3** | **Насны дээд хязгаар**<br>Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. |
| | Үгүй |
| **1.4** | **Шүүгчийн албан тушаал**<br>Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалан бичих/. |
| | Үгүй |
| **1.5** | **Улс төрийн болон намын удирдах албан тушаал**<br>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалан бичих/. |
| | Үгүй |
| **1.6** | **Эрүүгийн хариуцлага**<br>Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалан бичих/. |

| | |
|---|---|
| | Үгүй |
| **1.7** | **Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн**<br>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалллаар бичих/. |
| | Үгүй |
| **1.8** | **Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан**<br>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/. |
| | Үгүй |

## ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **2.1** | Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/ |
| | Миний бие шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүхийн хүний нөөц, бодлого төлөвлөлт, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах механизмыг боловсронгуй болгож, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг бэхжүүлэх бодит ажлыг хэрэгжүүлэхэд өөрийн ажлын туршлагаа өнөөгийн нөхцөл байдал болон практикт тулгуурласан шийдлийг гарган дэвшүүлж шийдвэрлэхэд дараах ажлыг зорилго болгоно. Үүнд:<br>**1.Шүүгчийн хараат бус байдлыг хангах бодлого**<br>-Шүүгчийн томилгоо, сонгон шалгаруулалт, шалгалтыг ил тод шалгуураар зохицуулах<br>-Шүүгчийн мэргэжлийн хөгжил, ёс зүйн тогтолцоог сайжруулах, нийгмийн хамгааллын баталгааг сайжруулах, гадаад дотоод нөлөөллөөс ангид орчин бүрдүүлэх<br>**2.Шүүгчийн сонгон шалгаруулалтыг сайжруулах**<br>-Мэргэшсэн, ёс зүйтэй, шударга хүмүүсийг шүүгчээр бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох<br>-Сонгон шалгаруулалтын процессыг нээлттэй, ил тод байлгах<br>**3.Шүүхийн захиргааны байгууллагын хөгжил, хүний нөөцийн бодлого, чадавхжуулалт**<br>-Тамгын газрын бүтэц, үйл ажиллагааг мэргэшсэн, тогтвортой, үр нөлөөтэй бодлого хэрэгжүүлэх<br>-Ажлын гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, урамшууллын систем нэвтрүүлэх<br>**4.Шүүхийн шинэтгэлийн бодлогыг дэмжих** |

| | |
|---|---|
| | -Шүүхийн шинэтгэлийг тууштай үргэлжлүүлж, хэрэгжилтийг хангах<br><br>-Олон улсын жишгийг судалж, дотоод нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх<br><br>Шүүхийн үйл ажиллагааны бодит нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлийг ойлгож мэдэрдэг хүний хувьд дээрх бодлогын шийдвэрүүд гаргахад оролцох чадамжтай, ёс зүй, мэдлэг, хариуцлага, тууштай байдал, мэргэжлийн үндэслэл надад бүрэн хангагдсан гэж үзэн нэр дэвшиж байна. |

**ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

| Д/д | Шалгуур үзүүлэлт |
|---|---|
| 3.1 | **Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал**<br>Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолтын гол агуулга;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;<br>-тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан тавaас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/. |
| | **1.Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа:** Тамгын газрын дарга, Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хороо, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн ажиллаж байна.<br><br>**Ажлын байрны тодорхойлолтын агуулга:** Шүүгчийн хараат бус бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргаа хүний нөөцөөр хангах, шүүхийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэгтэй<br><br>**Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл:** Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Ерөнхий шүүгч Б.Дашдондов, [redacted]<br><br>**Тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан хүний нэр: Хүний нөөц, дотоод ажил хариуцсан шинжээч** Д.Алтанбагана [redacted] Олон нийттэй харилцах мэргэжилтэн Э.Мягмаржав [redacted] нягтлан бодогч Г.Уранбилэг [redacted] бичиг хэргийн эрхлэгч Ж.Балжинням [redacted] мэдээлэл технологийн мэргэжилтэн Б.Гантулга [redacted]<br><br>**2.Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа:** Тамгын газрын дарга, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газарт 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл,<br><br>**Ажлын байрны тодорхойлолтын агуулга:** Шүүгчийн хараат бус бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргаа хүний нөөцөөр хангах, шүүхийн |

| | |
|---|---|
| | өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэгтэй<br><br>**Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл:** Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Ерөнхий шүүгч Б.Хишигбаатар, [redacted]<br><br>**Тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан хүний нэр:** Зохион байгуулалтын хэлтсийн дарга О.Төгөлдөр [redacted] Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн [redacted] Б.Лхагвадорж, шүүгчийн туслах Г.Нямаа [redacted], шүүгчийн туслах Б.Анхцэцэг [redacted], шүүгчийн туслах Б.Дашмаа [redacted]<br><br>**3.Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа:** Тамгын газрын дарга, Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, Аймгийн Шүүхийн Тамгын газарт 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр хүртэл,<br><br>**Ажлын байрны тодорхойлолтын агуулга:** Шүүгчийн хараат бус бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргаа хүний нөөцөөр хангах, шүүхийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэгтэй<br><br>**Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл:** Аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Г.Давааренчин утас: [redacted] ахмад шүүгч Л.Баяраа [redacted], ахмад шүүгч Д.Буянжаргал утас: [redacted]<br><br>**Тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан хүний нэр:** Үйлчилгээний хэлтсийн дарга Ж.Төмөрсүх [redacted], нягтлан бодогч Л.Одонтуяа [redacted] Шүүгчийн туслах Б.Мөнхзул [redacted] шүүгчийн туслах Ш.Энхцэцэг [redacted] шүүгчийн туслах Б.Болормаа [redacted]<br><br>**4.Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа:** Тамгын хэлтсийн дарга, Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, Аймгийн Шүүхийн тамгын хэлтэст 2005 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл,<br><br>**Ажлын байрны тодорхойлолтын агуулга:** Хэргийн хөдөлгөөний удирдлага, хяналт, мониторинг хийх, тамгын газрын үйл ажиллагаанд хэргийн хөдөлгөөний удирдлагыг уялдуулан өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,<br><br>**Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл:** Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, ахмад шүүгч Л.Баяраа [redacted]<br><br>**Тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан хүний нэр:** Б.Болор-Эрдэнэ [redacted] Б.Баярхүү [redacted] Г.Энхцэцэг [redacted] Н.Батхүү [redacted], Д.Мөнхцэцэг [redacted]<br><br>**5.Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа:** Хуулийн зөвлөх, мэргэжилтэн Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум, Мэргэжлийн хяналтын газарт 2004 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2005 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл,<br><br>**Ажлын байрны тодорхойлолтын агуулга:** Эрх зүйн актуудыг хуулийн дагуу гарахад хяналт тавих, байгууллагын эрх ашгийг хамгаалан |

| | |
|---|---|
| | хууль хяналтын байгууллагад төлөөлөх<br><br>**Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл:** Аймгийн Байгаль орчны газар улсын ахлах байцаагч Н.Эрдэнэцогт утас [redacted]<br><br>**Тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан хүний нэр:**<br><br>**6.Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа:** Хяналтын прокурор, Булган аймаг, Булган сум Прокурорын газарт 2001 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2002 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл,<br><br>**Ажлын байрны тодорхойлолтын агуулга:** Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих, шүүхэд төрийг төлөөлөх,<br><br>**Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл:** Булган аймгийн Прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурор П.Шижиртуяа утас:[redacted] |
| **3.2** | **Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил**<br>Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалалаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ. |
| | Үгүй |
| **3.3** | **Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар**<br>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалалаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалалаар бичнэ. |
| | 2004 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч,<br><br>2006-2023 Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн гишүүн,<br><br>2010 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс Шүүхийн захиргааны ажилчдын холбооны гишүүн, удирдах зөвлөлийн гишүүн,<br><br>2020 оноос Сэлэнгэ аймгийн хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүн,<br><br>2023 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс Баянгол, Сонгинохайрхан дүүргийн хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүн,<br>2023 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс Баянгол дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн<br>2023 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс Хан-Уул дүүргийн гэмт |

| | |
|---|---|
| | хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн<br>2023 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс Сонгинохайрхан дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн |

## ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

| | |
|---|---|
| **4.1** | **Хууль зүйн өндөр мэргэшил**<br>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ:<br>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>-үйл ажиллагааны гол агуулга;<br>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;<br>-тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;<br>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. |
| | **Нэг.**<br>**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Сэлэнгэ аймгийн шүүхийн тамгын газарт ажиллаж байхдаа 2013.07.08-ны өдөр “Зууны мэдээ” сонин Эрх зүйн боловсролыг иргэдэд хүртээмжтэй олгох тухай ярилцлагыг https://www.zms.mn/a/2491 сайтаас үзэх боломжтой.<br><br>**Хоёр.**<br>**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар,** Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангах, иргэн төвтэй шүүх болох зорилтын хүрээнд “ХУРДАН” киоск төхөөрөмжийг шүүхийн байранд байршуулав. Киоск төхөөрөмж байршуулснаар иргэд төрийн мэдээллийг нэг цэгийн үйлчилгээ болон өөр газар очиж авахгүйгээр шүүхээр үйлчлүүлэх хялбар болсон.<br>**хугацаа: 2024.09.18**<br>https://www.facebook.com/photo/?fbid=953996626754322&set=pcb.953996833420968<br><br>**Гурав.**<br>**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд “Иргэд өөртөө үйлчлэх хэсэг” буюу нэхэмжлэл хүсэлтийн загвар, эвлэрүүлэн зуучлалын өргөдлийн загвар болон QR кодыг уншуулан хэргийн оролцогчдын эрх үүрэг таниулах гарын авлага хуудсыг хэвлэн авах боломжийг бүрдүүлэв.<br>**хугацаа: 2024.08.20**<br>https://www.facebook.com/photo/?fbid=933049138849071&set=pcb.933049542182364 |

**Дөрөв.**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд сүүлийн жилүүдэд хийгдээгүй байсан засварыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд уламжлан шүүхийн үйлчилгээний угтах хэсгийг сайжруулан засварлах ажлыг хийж, Шүүгч, шүүхийн захиргааны ажилчид, иргэдэд таатай орчин бүрдүүлэв.

**хугацаа: 2024.07.22**

https://www.facebook.com/photo/?fbid=913179684169350&set=pcb.913181614169157

**Тав.**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд Шүүхээр үйлчлүүлж буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан авто машины зогсоол байгуулав.

**хугацаа:** 2023.10.15

https://www.facebook.com/photo/?fbid=734248532062467&set=pcb.734248598729127

**Зургаа. Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:** Хоригдож байгаа яллагдагч, шүүгдэгчтэй уулзах зөвшөөрөл авах иргэдийн хэрэгцээ шаардлагад үндэслэн **e-uulzalt.mn** буюу уулзалтын бичгийг цахимаар олгодог сайтыг нэвтрүүлэв.

**хугацаа:** 2024.04.16

https://www.facebook.com/profile/100089704061144/search/?q=uulzlalt

**Долоо.**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:**

Хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхэд шүүхээр тайван үйлчлүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байгаагаас улбаалан, шүүх хуралдаанд хохирогчид болон ялангуяа хүүхдийг гэмт этгээдтэй нүүр тулгахгүйгээр шүүх хуралдаанд тайван оролцуулж тэдний эрхийг хамгаалах, сэтгэл зүйн онцлогийг харгалзаж, айдасгүй тав тухтай хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хүүхэд хамгааллын нийгмийн бодлогын хүрээнд насанд хүрээгүй гэрч, хохирогчийн өрөөг ашиглалтад оруулав.

**хугацаа:** 2025.07.03

https://www.facebook.com/photo/?fbid=713266661673463&set=pcb.713268211673308

**Найм.**

**Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа:**

Шүүх, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын дунд "Гүйцэтгэх хуудасны хяналтын систем"-ыг шинээр нэвтрүүлж эхлэв. Тус систем нь

1. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг цахим орчинд бүртгэх, хянах
2. Иргэд, байгууллагад ил тод мэдээлэл хүргэх
3. Гүйцэтгэлийн явцыг байгууллага хооронд шуурхай солилцох
4. Ажилтны ажлын ачааллыг бууруулах
5. Цаг хэмнэх
6. Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх
7. Мэдээ, тайлан гаргах зэрэг ач холбогдолтой юм.

**Хугацаа.** 2025.08.20

| | |
|---|---|
| | https://www.facebook.com/photo?fbid=759488430384619&set=pcb.759491123717683 |
| **4.2** | **Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл**<br>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.<br>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.<br>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.<br>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.<br>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана. |
| | **Нэг.** 2016.02.19-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 77 дугаар тогтоолоор батлагдсан “Хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг мэдээлэх журам” нь 2016 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Миний Монгол” КаТВ-ийн сэтгүүлч, “Гэгээ”, “Сэлэнгийн мэдээ” сонины эрхлэгч нарт журмын талаар мэдээлэл өгөв.<br><br>https://www.facebook.com/photo/?fbid=522046767920507&set=pcb.522047084587142<br><br>**Хоёр.** 2016.06.01-ний өдөр Сэлэнгэ аймагт шүүх байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг тохиолдуулан Сэлэнгэ аймаг дахь шүүхийн Тамгын газраас Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Ёс зүй” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулав.<br><br>https://www.facebook.com/photo/?fbid=559012297557287&set=pcb.559012894223894<br><br>**Гурав.** 2015.11.05-ны өдөр Сэлэнгэ аймаг дахь шүүхийн тамгын газраас “ШҮҮХ ДЭХ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦОО” сэдэвт иргэдтэй уулзах өдөрлөгийг Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд зохион байгуулав.<br><br>https://www.facebook.com/photo/?fbid=492250914233426&set=pcb.492251224233395<br><br>**Дөрөв.** Сэлэнгэ аймаг дахь Хил хамгаалах туслах хүчний зөвлөлөөс “Монгол Улсын Хилийн тухай хууль”-ийн 149 дүгээр зарлигаар батлагдсан “Иргэдийг Улсын хил хамгаалалтад оролцуулах тухай” журмын хэрэгжилтийг хангуулах, хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоог |

| | |
|---|---|
| | нэмэгдүүлэх зорилгоор 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан нэгдсэн зөвлөгөөнд шүүхийн Тамгын газрын дарга М.Нямсүрэн урилгаар оролцов.<br><br>https://www.facebook.com/photo/?fbid=514334622025055&set=pcb.514335205358330<br><br>**Тав.** 2016.05.30-ны өдөр Сэлэнгэ аймагт шүүх байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг угтаж хийх “БҮТЭЭЛЧ-9 АЖИЛ” төлөвлөгөөний дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумдад 2016 оны 05 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Шүүхийн багц хуулийн хэрэгжилт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулан ажиллав.<br><br>https://www.facebook.com/photo?fbid=557898121002038&set=pcb.557898761001974<br><br>**Зургаа.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 189 дүгээр зарлигаар шүүгч нарыг Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсон билээ. Сэлэнгэ аймаг дахь шүүхийн тамгын газраас 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр “ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ” гардуулах арга хэмжээг зохион байгуулж, Сэлэнгэ аймаг дахь шүүхийн Тамгын газрын дарга М.Нямсүрэн шинээр томилогдсон Ерөнхий шүүгч нарт Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг танилцуулан зарлигийг гардуулан өгөв.<br><br>https://www.facebook.com/photo/?fbid=507728432685674&set=pcb.507744059350778<br><br>**Долоо.** Сэлэнгэ аймаг дахь шүүхийн Тамгын газраас Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар баталсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”, Тахарын Ерөнхий газрын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын хамтарсан “Зөвлөмж”, журамд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх, хоёр байгууллагын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Тахарын албаны Сэлэнгэ аймаг дахь хэсэгтэй 2016 онд хамтран ажиллах төлөвлөгөөг батлан, хамтарсан зөвлөгөөн зохион байгуулав. 2016 онд хамтран ажиллах төлөвлөгөөг Сэлэнгэ аймаг дахь шүүхийн Тамгын газрын дарга М.Нямсүрэн танилцуулж, цаашид хамтын үйл ажиллагаагаа сайжруулах болон анхаарах асуудал зэрэгт санал бодлоо солилцон, харилцан ярилцсанаар хамтарсан зөвлөгөөн амжилттай болж өндөрлөв.<br><br>https://www.facebook.com/photo/?fbid=508344912624026&set=pcb.508345105957340<br><br>**Найм.** Сум дундын 20 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Л.Энхтайван, Тамгын газрын дарга М.Нямсүрэн, шүүгч Б.Эрдэнэхишиг, эвлэрүүлэн зуучлагч Д.Мөнхцэцэг, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Э.Бүүвэйцэцэг нарын хамт Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумand “Нээлттэй шүүх” өдөрлөг зохион байгуулж, “Шүүхийн тухай” багц хуулийн хэрэгжилт болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн хорооны талаар сурталчилж, иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч ажиллалав. |

| | |
|---|---|
| | https://www.facebook.com/photo/?fbid=434548126670372&set=pcb.434548330003685<br><br>**Ес.** Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газарт ажиллаж байхдаа шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах иргэдийн тав тухай үйлчлүүлэх боломжийг хангаж хүний эрхийг дээдлэх, хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт хүний эрхийг хангах, тэдэнд төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх зорилгоор "Тусламжийн хонх"-ыг шүүхийн байрны үүдэнд байрлуулав.<br><br>https://www.facebook.com/photo/?fbid=657708397229290&set=pcb.657708530562610<br><br>**Арван.** Шүүхийн байрны гаднах явган хүний болон авто зам, талбай төлөвлөлтөд тавих шаардлага хангаагүй стандарт бус учраас шүүхээр үйлчлүүлж буй иргэд, шүүхийн хуяглан хүргэх авто автомашины орц, гарцын асуудалд хүндрэл үүсэж байсан тул тус шүүхийн Тамгын газраас хүсэлт гарган гаднах зам засвар, өргөтгөлийн ажлыг хийлгэв.<br>https://www.facebook.com/photo/?fbid=727534126913383&set=pcb.727534730246656 |
| **4.3** | **Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ)**<br>Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалан бичих/. |
| | Тийм<br><br>-2014.07.07 Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ, №2012 Монголын Хуульчдын холбоо (11 жил 3 сар)<br><br>-2007.02.21 Шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаал эрхлэх сонгон шалгаруулалтад оролцох, өмгөөллийн болон нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажиллах хуульчдын 2004 оны сонгон шалгаруулалтад тэнцсэн гэрчилгээ, №0002325 Хуульчдаас сонгон шалгаруулах ажлыг эрхлэн гүйцэтгэх орон тооны бус зөвлөл (9 жил 9 сар) |
| **4.4** | **Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл**<br>Суралцаж төгссөн их, дээд сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дараалан жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, эрдмийн зэрэг, цол авсан огноог бичнэ.<br>Тийм<br><br>2011-2013 онд Их засаг Олон улсын их сургууль, Хууль зүйн сургуулийн эрх зүйч (Магистр) |

| | |
|---|---|
| **4.5** | **Сахилгын шийтгэл**<br>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалласаар бичих/. |
| | Үгүй |

**Хавсралт:**

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

-төрийн албан хаагчийн анкет;
-иргэний үнэмлэхийн хуулбар;
-нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

-эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;

-хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;

-эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;
-энэхүү загварт заасан баримт бичиг;
-холбогдох бусад баримт.

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Мондоохой

Өөрийн нэр: Нямсүрэн

Гарын үсэг: ………………………………………

Он, сар, өдөр: 2026.05.27

---oOo---